



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/336

Есөнбулаг

Д.Баянмөнхөд ажлын хөлс олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны "Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай" 10 дугаар тогтоол, "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 11 дүгээр тогтоол, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 24 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нэгдсэн Үндэстний Байгууллагын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага буюу Юнеско-д 2009 онд бүртгэгдсэн Монгол тууль, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/759 дүгээр тушаалаар баталсан Монгол Улсын яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өв болох "Монгол Жангар хайлах" өвийг хамгаалах, сурталчлах, өвлүүлэх, "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.4 дэх зорилгыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулагдсан "Туульсын хаан Жангар" арга хэмжээний хөгжмийг найруулж, зөвлөн тусалж ажилласан Ардын дуу бүжгийн "Алтай" чуулгын хөгжимчин, багш Д.Баянмөнхөд 1,000,000 төгрөгийн ажлын хөлс олгосугай.

2.Шаардагдах 1,000,000 (нэг сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

